



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Оточманрамба их сургууль

Хөтөлбөрийн нэр: “Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөр

Индекс: D091701

Шинжээчийн баг:

Ахлагч: Ч.Чимэдрагчаа

Гишүүд: Ч.Батнайрамдал

Х.Туул

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	10
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	14
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	15
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	18
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	24
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	28
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	34
I. Багш нарын нэрс	35
II. Оюутнуудын нэрс	35
III. Ажил олгогчдын нэрс	36
IV. Төгсөгчдийн нэрс	36
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	37
VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

ЭШ	Эрдэм шинжилгээ
СА	Сургалтын алба
ОА	Оюутны алба
ИС	Их сургууль
УАУ	Уламжлалт анагаах ухаан
АУИС	Анагаах ухааны их сургууль
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
УАС	Уламжлалт анагаахын сургууль
ШАУС	Шинэ анагаах ухаан сургууль
МУ	Монгол улс
ӨАУ	Өрнийн анагаах ухаан
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
УМС	Удирдлага мэдээллийн систем
МУЭСТ	Монголын уламжлалт эмнэлэг сургалтын төв
ДХШЧУА	Дотоод хяналт шинжилгээ, чанарын үнэлгээний алба
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ШУ	Шинжлэх ухаан
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ТББ	Төрийн бус байгууллага
МИДСК	Монголын их дээд сургуулиудын концерциум
ОХ	Оюутны холбоо

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Оточ манрамба их сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөр	
Индекс	D091701	
Шинжээчид	<p>Ахлагч: Ч.Чимэдрагчаа – Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн захирал, академич</p> <p>Гишүүд: Ч.Батнайрамдал – АШУҮИС-ийн МАУОУС-ийн Дотор өвчин судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор</p> <p>Х.Туул – Эмзүйн шинжлэх ухааны их сургуулийн Уламжлалт анагаах ухааны сургуулийн Уламжлалт анагаах ухаан судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор</p>	
БМИҮЗ-ийн мэргэжилтэн	Б.Мядагмаа-БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.5.13	Уламжлалт анагаах ухаан хөтөлбөрийн нотлох баримттай сургууль дээр нь очиж танилцсан.
	2021.5.14	Багш, оюутан, ажил олгогч, төгсөгчдийн төлөөлөлтэй цахим уулзалтуудыг хийсэн
	2021.5.14.	Сургуулийн өөрийн үнэлгээний багт цахимаар шинжээчийн үнэлгээний тайланг урьдчилсан байдлаар танилцуулсан.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Оточ Манрамба Их сургууль нь 1991 онд байгуулагдсан цагаас Уламжлалт ангаах ухаан бакалаврын хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Хөтөлбөрийн шинэчлэлийг нийт 5 удаа хийсэн.

Уламжлалт Анагаах Ухаан хөтөлбөр нь хуучин Манба Дацангуудын эмч бэлтгэдэг байсан сургалтын уламжлалт, сонгодог “Шүн”-ийн сургалтын аргазүйг орчин үеийн сургалтын аргазүйтэй хослуулан хэрэгжүүлдгээрээ онцлог давуу талтай.

Уламжлалт Анагаах Ухааны үндсэн сурах бичгийг багш Төвөд хэлнээс орчуулан, хөтөлж, тайлбарлан явуулах бөгөөд шүнгийн гол утга санааг тайлбарлуулах, цээжлүүлэх, орчуулах, хооронд нь холбож мэтгэлцээн өрнүүлэх, эмнэл зүйн дадлагад ашиглах чадамжийг бий болгох зэрэг үндсэн аргачлалаар дамжуулан тус хөтөлбөрөөр суралцаж буй суралцагсдад УАУ-ы онол, дадлагын талаар цогц мэдлэг, чадвар, чадамжийг олгодог нь шүнгийн сургалтын давуу тал болно.

Багшлах боловсон хүчин нийт 49 үндсэн багштай. Нийт багшлах бүрэлдэхүүний 42.5% нь улсад мэргэжлээрээ 10 болон түүнээс дээш жил ажилласан эрдэмтэн багш нар, 42.5% нь 5-10 жил ажилласан, 15% 1-5 жил ажиллаж байгаа шинэ залуу багш, эрдэм шинжилгээний ажилтнууд байна. Багш нарын 65% нь Магистр, 27% нь Доктор зэрэгтэй, 29% профессор, 2% нь дэд профессор, 17 % нь ахлах багш, 46 % нь багш, 6% нь дадлагажигч багш байна.

2020-2021 оны хичээлийн жилд УАУ-ы хүний их эмч мэргэжлээр 1-6 курсд 318 оюутан суралцаж байна.

2020 оны байдлаар УАУ-ы хүний их эмчийн мэргэжлээр 19 удаагийн төгсөлт хийгдсэн ба нийт 691 төгсөгч төгсгөсөн байна. Төгсөгчдийн 27.9 хувь нь буюу 91 төгсөгч мэргэжлийн зэрэг дээшлүүлсэн бөгөөд энэ нь дөрвөн төгсөгч тутмын нэг нь мэргэжлийн зэргээ ахиулсан байгааг харуулж байна. Үүнээс зөвлөх зэрэгтэй эмч 3, тэргүүлэх зэрэгтэй эмч 21, ахлах зэрэгтэй эмч 67 байна. Боловсролын зэрэг ахиулсан төгсөгчид доктор 9, докторантурт суралцаж буй 23, магистр 119, магистрантурт суралцаж буй 91, нийт 242 буюу 35.02%-ийг эзэлж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой байна.
- Оточ манрамба их сургууль нь БШУ-ы сайдын А/78, А/174, А/285, А/103 тоот тушаалуудын дагуу бакалаврын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан сургалтын үйл ажиллагаа эрхлэн ажилласан байна.
- Оточ манрамба их сургууль нь 1991 оноос Уламжлалт анагаах ухаан хүний их эмч мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд 2019 онд төгссөн төгсөгчдийн дунд сургалтын хөтөлбөрийн давуу, сул талыг судлан үзэхэд хөдөлмөрийн зах зээлд зохицох байдал 10% хувь нь сул талтай гэж үнэлгээ өгсөн байна.

Анхаарах асуудал:

- Уламжлалт анагаах ухаан эмч мэргэжилтний хэрэгцээ шаардлага ямар байгааг судалж тогтоосон судалгаа хийсэн боловч хөтөлбөрт холбож уялдуулах тал дээр бага зэрэг дутагдалтай ажилласан байна гэж үзэж байна.
- “Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөрийн шинэчлэлийг БСШУСЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд CDIO (conceive-сэтгэх, design-бодох, implement-бүтээх, operate-хэрэглэх), PDCA циклийн хүрээнд “21 зуун дахь уламжлалт анагаах ухааны боловсрол”-ын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулах шаардлагатай байна.

Шаардлага:

- Хөтөлбөрийг сайжруулах зорилгоор оюутан, мэргэжлийн багш, мэргэжилтэн ажил олгогчтой тогтмол хэлэлцүүлэг зохион байгуулж хөтөлбөр сайжруулах зорилгоор олон төрөлт ажил зохион байгуулах, багш, оюутан, төгсөгчид,

ажил олгогчдын саналыг тусгах, хөтөлбөрийн давуу, сул талын судалгааг тодорхой давтамжтай явуулж, хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэх

- Хөтөлбөрийн зорилгыг онол, практик хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд чиглүүлэн тодорхойлж ажиллах
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк хийх

1.2. Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримтууд
- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материалууд
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилгод судалгаа хийсэн байдал
- Хөтөлбөрийн зорилго, байгууллагын эрхэм зорилго зорилт
- Хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч талуудын саналыг тусгасан байдал
- Хөтөлбөрийн зорилгыг олон нийтэд түгээдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Уламжлалт анагаах ухааны их эмч нь хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлоготой нягт уялдуулан Өрнө Дорны АУ-ыг хослон хэрэгжүүлэх мэргэжилтэн бэлтгэх зорилготой.
- Чадвартай, хүнлэг, энэрэнгүй сэтгэл оюунтай эмч мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн зорилго оршиж байгаа нь сайшаалтай.
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг ЭМЯ, ЭМХТ-ийн эмнэлгийн ажилтны хөгжүүлэх албанаас зохион байгуулан авдаг төгсөгчдийн эмчлэх эрхийн зөвшөөрөл авах шалгалтын дүнгээс харахад мэргэжлээр төгсөгчдийн үзүүлсэн амжилт сүүлийн 5 жилийн дунджаар 86% байгаа нь хөтөлбөр төлөвлөлт үр дүндээ тодорхой хүрч чадаж байгааг харуулж байна гэж үнэлжээ.
- Ажил олгогчдын зүгээс хамгийн өндөр сэтгэл ханамжтай ур чадвараар төгсөгчдийн Харилцааны ур чадварыг онцолж байгаа нь тус сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгад буй харилцааны ойлголт, анагаах ухааны зурхай, эмнэлгийн эрх зүй, эмчийн эрх зүй зэрэг харилцаа, хандлага, ёс зүйн хичээлүүд түлхүү орж байгаатай холбоотой гэж үзсэн байна.

Анхаарах асуудал:

- ДЭМБ болон Ази номхон далайн бүсийн орнуудын уламжлалт анагаах ухааны стратеги, бодлоготой уялдуулж үзэл баримтлал, зорилгоо тодорхойлох шаардлагатай байна.
- УАУ-ы мэргэжилтэнд ажил олгогч нарын өгч буй үнэлгээ, судалгааг дэлгэрэнгүй 3 – 5 жилээр нь гаргаж дүн шинжилгээг хийж байх хэрэгтэй

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал нь ДЭМБ болон Ази номхон далайн бүсийн орнуудын уламжлалт анагаах ухааны стратеги, бодлоготой уялдуулах
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулан ажиллах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал
- Батлагдсан хөтөлбөр,
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр
- Гамшгаас хамгаалах менежмент хичээл яаралтай тусламжийн хичээлийн дээр тусгагдсан байна.
- Сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг ханган баталгаажуулсан
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график, хөтөлбөрийн \PLO\болон хичээлийн \CLO\ суралцахуйн үр дүнгийн төлөвлөлт
- Хичээлийн хөтөлбөрийг баталгаажуулахдаа сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглүүлж, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоог ханган, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Уламжлалт сурвалж судлал, эх бичиг, тайлбарууд их хэрэглэдэг нь сайшаалтай байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдалд хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна.
- БСШУ-ы Сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалын хүрээнд бакалаврын хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу 12 бүрэлдэхүүн хэсэг бүхий баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, А/285, А/103 тушаалуудыг хэрэгжилтийг хангаж ажиллах
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар өөрийгөө илэрхийлэх, сэтгэн бодох чадвар дээр сэтгэл ханамж бага байгаа нь анагаах ухааны мэргэжлийн онцлогтой холбоотой байна. Тиймээс цаашид төгсөн гарч буй төгсөгчийн өөрийгөө илэрхийлэх, сэтгэн бодох чадваруудыг хөгжүүлэх тал дээр анхаарч хөтөлбөрийн агуулгад тусгаж ажиллах
- Хөтөлбөрийг бусад УАУ-ы их эмч бэлтгэдэг гадаад, дотоодын хөтөлбөртэй харьцуулан дүн шинжилгээг хийж ажиллах

Зөвлөмж:

- БШУ-ы сайдын А/285, А/103 тушаалын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах
- Харилцааны ур чадвар, Анхны тусламж, Мэргэжлийн суурь ур чадварын хичээлийн агуулга бүхий хичээлийн хөтөлбөрт тусгаж өгөх
- 1 долоо хоногт орох оюутан, багшийн цагийн ачаалал жигд хуваарилж ажиллах
- Лекц, дадлага, семинар, бие даалтын зохист харьцааг баримтлах
- Цаашид төгсөн гарч буй төгсөгчийн өөрийгөө илэрхийлэх, сэтгэн бодох чадваруудыг хөгжүүлэх тал дээр анхаарах
- Хувь хүний хөгжил сурах арга барил дээр хослуулан хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
 - Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ байгууллагын харьцуулсан шинжилгээ
 - Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
 - Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байдал
 - Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
 - Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
 - Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
 - Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- УАУ-D091701 хөтөлбөрийн хүрээнд сургалтын батлагдсан хөтөлбөрт багтах бүх хичээлүүдийн агуулгын 10 орчим хувийг хөтөлбөр хэрэгжүүлэгч профессорын багаас дэвшүүлсэн шинэ үзэл баримтлал, шинэ мэдлэгийн агуулгаар баяжуулан зааж байгаа нь их сургууль мэдлэгт суурилсан, шинжлэх ухаанд суурилсан сургалт, судалгаа, инновацыг бий болгох ёстой гэсэн төр засгийн бодлоготой уялдаж байна.
- Уншиж судлах нэгж хичээлийн материал, word дээр дэлгэрэнгүй бэлтгэгдсэн байна.
- Хичээл тус бүрээр оюутны хөтөч боловсруулан сургалтдаа хэрэглэж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн агуулга дээр нэгдмэл анагаах ухаан агуулга хоорондын уялдаа холбоог тусгаж өгөх
- Сургалтын арга зүй, сургалтын төгсгөлд оюутныг үнэлэх зарчим нь ном сурах бичгээс олж авсан мэдлэг, багшийн өгсөн мэдлэг, сургалтын хөтөлбөрийн хүрээнд бий болсон шинэ мэдлэгийн агууламжийг оюутан хэрхэн эзэмшсэнийг зөвхөн үнэлэх бус олж авсан мэдлэгийг оюутан хэрхэн бүтээлчээр задалж, шинжилж, өөрийн болгож байгаа бүтээлч ажиллагааг хөхүүлэн дэмжих үнэлгээний зарчмыг баримтлах
- Хөтөлбөрийн нийт багц цагийн сонгон суралцах хичээлийн эзлэх хувийг үе шаттай нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Дадлага сургалтын талаарх хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ бусад эмнэлгүүдтэй хамтран ажиллах гэрээ

байхгүй

- Уламжлалт анагаах ухаан, Өрнийн анагаах ухааны хичээлүүдээс гадна нэгдмэл анагаах ухааны талаарх агуулгыг хичээлийн хөтөлбөрт тусгаж өгөх
- Зайн, цахим хичээлийг E-контентийн түвшинд боловсруулан, E-сургалтыг боловсронгуй болгох
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог босоо ба хэвтээ тэнхлэгт уялдуулж шаардлага хангаж ажиллах

2.2. Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөрт тусгагдсан мэргэжлийн хичээл бүрийг “Оточ манрамба” бааз эмнэлгийг түшиглэн дадлагажих боломж бүрдүүлж, гардан үйлдэлд сургадаг, оюутнууд хичээлийн бус цагаар багш, эмчийн удирдлага доор эмнэлэгт жижүүрт гарах эмчийн туслах хийх зэргээр ажиллаж орлого олох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Зуны үйлдвэрлэлийн дадлагын заавар, журам нотлох баримт бичгийг эмх цэгцтэй болгох
- Сургалтын арга зүйг уламжлалт болон орчин үеийн анагаахын шинжлэх ухааны нээлт, ололт амжилтад үндэслэн, шинэчилж боловсронгуй болгох
- Сургалтын арга зүй нь мэдлэгийг бүтээж, хэрэглээ болгон суралцах үйл явцыг эрх зүйн хувьд баталгаажуулах

Зөвлөмж:

- Өрнийн анагаах ухааны эмнэлгүүд дээр дадлага хийх гэрээ, заавар журмыг тодорхой хийх.
- Сонгон суралцах хичээлүүдийн эзлэх хувь харьцааг нэмэгдүүлэх, хичээлүүдийг жигд хуваарилах

2.3. Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга

зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Судар ном цээжлүүлэх, орчуулга хийх зэрэг сургалтын уламжлалт аргыг сургалтанд хослуулан ажиллаж байна.
- Оюутны мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг үнэлдэг асуулга, шалгалтын арга зүйг тогтмол сайжруулан, онолын түвшинд дүгнэдэг байна.

Анхаарах асуудал:

- Оюутныг үнэлэх үнэлгээний журмыг боловсронгуй болгож, тэдний хүмүүжил, төлөвшил, аливаа зүйлд хандах хандлага, харилцааны соёлыг үнэлэх шалгуурыг төгөлдөржүүлэх
- Сургалтад үнэлгээний тогтсон аргачлал ашиглаж, үнэлгээний арга зүйн талаарх судалгаатай ажиллах. /Блум таксономи, Рубрик, 360 хэм аргууд г.м/
- Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнг хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдуулан шинэчлэх

Шаардлага:

- Оюутныг үнэлэх журмыг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх
- Суралцагчийн сурлагын амжилт, чанар, ахиц дэвшлийн талаарх судалгааг тогтмолжуулах, статистик мэдээлэл, боловсруулалт, дүн шинжилгээг сайжруулах
- БШУ-ы Сайдын 2014 оны А/285 дугаар тушаал, А/103 дугаар тушаалын хүрээнд ерөнхий суурь чиглэлд заавал судлах Монгол хэл бичиг, найруулга зүй; Хүний хөгжил харилцааны ёс зүй, Сэтгэлгээний түүх соёл зэрэг хичээлүүд сонгон судлах хэлбэрээр төлөвлөгдсөнөөс гадна Гамшгаас хамгаалах менежмент хичээл тусгаагүй байна. Иймд А/285 дугаар тушаалыг баримтлах
- Дурдсан хичээлүүдийн судлах багц цагийн хэмжээ тушаалд зааснаас бага байгаа зэргийг анхаарч сургалтын төлөвлөгөөг засаж сайжруулах шаардлагатай.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1. Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- 2013-2020 онд хичээлийн шинэ байр
- Сургалтын бааз Манба Дацан Нэгдсэн эмнэлгийн шинэ байр
- Химийн болон эмийн химийн лаборатори
- Ногоон байгууламж
- Эмийн үйлдвэрийн өргөтгөл
- Дотуур байр, сургуулийн урсгал засварын ажил зэргийг хийж гүйцэтгэсэн.
- Жил бүр сургууль, эмнэлэг, эмийн үйлдвэр, лабораторид тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- Монгол Улсын хууль, дүрэм, журмын хүрээнд Монгол улсын MNS5323-128:2012 стандартад нийцүүлэн боловсруулж, эрдмийн зөвлөлийн шийдвэр, захирлын тушаалаар батлагдсан хөтөлбөрөөр үйл ажиллагаагаа явуулдаг.

Анхаарал зүйл:

- Цахим хичээлийн санг улам боловсронгуй болгож E-контент сургалтыг явуулах.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- 195 хүний суудалтай 2 ээлжээр буюу 24 цагаар ажилладаг номын сантай
- Номын сан 11.053 ном, сурах бичиг, гарын авлагатай.
- 1025 цахим номын сантай.
- Энэ нь суралцаж буй суралцагчдад хангалттай хүрэлцээтэй байна.

Анхаарах зүйл:

- Цахим номын тоог олшруулах.

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- 2015-2016 оны хичээлийн жилд холбогдох хууль журмын хүрээнд бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжлийн экспертиз хийж, бодлого, зөвлөмж, шийдвэр гаргах зорилгоор Оточ Манрамба ИС-ийн хөтөлбөрийн хороог захирлын 2016 оны 05 сарын 24-ний өдрийн А/25 тоот тушаалаар шинээр байгуулсан
- 2014-2021 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг Оточ Манрамба ДС-ийн УЗ-ийн 2014 оны 08 сарын 25-ны хурлын 01 тогтоолоор батлан, хэрэгжүүлж байна.
- Оюутнуудаас ирсэн өргөдөл, санал гомдлыг тухай бүрд хүлээн авч холбогдох дүрэм журмын дагуу шийдвэрлэсэн байна. Судалгаа хийсэн.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- Гадаад хамтын ажиллагаа. (Япон, Орос, Болгар, БНХАУ, Англи, Тайвань)
- 2014-2019 оны байдлаар ОУ-ын хуралд 6 удаа оролцсон.
- 2015-2017 онд гэрээ, хамтын ажиллагаа 4, 2013-2020 онд санамж бичиг 7 тус тус байгуулсан байна.
- Гадаад оронд мэргэжил дээшлүүлсэн 5 багш
- Гадаад оронд доктор хамгаалсан 2 багш
- Гадаад оронд магистр хамгаалсан 5 багш

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа хавсаргасан байна.
- Төгсөгчдийн давтан сургалт нийт 2017-2019 онд нийт 14 удаа явуулж 341 хүн хамрагдсан.

Анхаарал зүйлс:

- Төслийн нэршил, санхүүжилтийн гэрээ, хүлээлгэж өгөх үр дүнгийн даалгаврыг тодорхой болгох.

4.3. Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайланг хөтөлбөрт тусгасан. Нийт их эмчийн хөтөлбөрийн зардал 63,7% эзэлж байна.
- Төрийн зээл 28%,
- 103 оюутан төрөөс үзүүлэх зээл тусламжид хамрагдсан. Үүнээс 28 оюутан төрийн сангийн буцалтгүй тэтгэмж, 75 оюутан, оюутны хөгжлийн зээлд, 1 оюутан засгийн газрын тэтгэлэг хөтөлбөрт тус тус хамрагдсан байна. Мөн 9 оюутан шинэ монгол, дэлхийн зөн, ОМИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэгт хамрагдсан байна.

Анхаарах зүйл:

- Нэг суралцагчдад ноогдох өртөг зардлын тооцоог тодорхой болгох.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй тусгах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- 2018-2019 оны судалгаагаар 82,5% сургалтын чанар сайн.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 47,7% сайн.
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт хавсаргасан байна.

Анхаарар зүйл:

- Хөтөлмөрийн зах зээлийн тандалт судалгааг тогтмол явуулах
- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн стратегийг нэгтгэж сурталчлах, түүний үр ашиг, хамрах хүрээг тодорхойлох.
- Маркетингийн идэвхжүүлэлтийн иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийг нэгтгэн дүгнэх.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вэбсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- Сургуулиас эрхлэн гаргадаг “Уламжлалт анагаах ухаан” сонинд 2011-2019 оны хооронд 63 дугаарт 500 гаруй нийтлэл материал хэвлүүлсэн.

www.facebook.com/manbadatsancentre

www.facebook.com/otochManramba/

www.facebook.com/manbadatsanemneleg/

www.facebook.com/ManbadatsanMonastery/

www.facebook.com/ManbadatsanPharmacy/

- Вэбсайтын мэдээллийн иж бүрэн байдал тогтмол

www.otoch.edu.mn

www.manbadatsan.mn www.natsagdorj.manbadatsan.mn

Анхаарах зүйл:

- Цаг үеийн мэдээллийг тогтмол байршуулж, цахим мэдээллийн жагсаалтыг идэвхтэй байлган олон нийтэд ил тод, үнэн зөв мэдээлэх.

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журамтай.
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцааны судалгаа хийсэн.
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага номын санд байршсан.
- Гадаад оюутан элсэн суралцдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- БСШУЯ-ы сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”-ыг баримтлан жил бүрийн Оточ Манрамба ИС-ийн захирлын тушаалаар батлагдсан Оюутан элсүүлэх журмыг мөрдөн, элсэлтийн комисс байгуулж, элсэлтийн ажлыг зохион байгуулдаг.
- Элсэлтийн бүртгэлийг Улаанбаатар хотод цахим хэлбэрээр <http://otoch.edu.mn> хаягаар болон сургуулийн байранд, хөдөө орон нутагт МИДСК-аар дамжуулан элсэлтийн үйл ажиллагааг явуулдаг. Тус сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтын хичээл тус бүрд 400-с дээш оноо авсан элсэгчдийг элсүүлэн авдаг.
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо сүүлийн таван жилийн дундаж нь 442,2 ба хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа 1:1 байна.
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээллийг хичээлийн жилийн эхэнд Удиртгал хичээл хэлбэрээр сургуулийн сургалтын албанаас зохион байгуулж, мэргэжлийн чиг баримжаа олгож, тус сургуулийн сургалтын онцлог давуу талуудыг танилцуулан, Оточ Манрамба ИС-ийн дадлагын бааз Манба Дацан эмнэлэг УАУ-ы түүхийн музей тайлбарлан танилцуулдаг. Сургуулийн номын санд Оюутны гарын авлага байдаг. Түүнд суралцах хугацаанд баримтлах дүрэм журам тусгагдсан.
- Гадаад оюутны элсэлтийн тоо сүүлийн таван жилд нийт 7 орны 25 оюутан элсэн суралцсанаас 2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар төгссөн болон сургуулиас гарсан оюутныг хасаад 16 оюутан суралцаж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад оюутан суралцдаг.

Анхаарах асуудал:

- Оюутны тоог нэмэгдүүлэх, маркетингийн сурталчилгааг идэвхжүүлэх

Зөвлөмж:

- УАУ-ы эмчийн мэргэжлийн онцлог, сургалтын давуу талыг Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад түгээн сурталчлах

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлантай.
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материалыг архивласан.
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээг нэгтгэсэн.
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээг нэгтгэсэн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

- Оюутанд зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөгөөг жил бүр тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган багш бүр даасан ангидаа хүргэж, жилийн эцсийн үйл ажиллагааны тайландаа тусгадаг.
- Оюутанд чиглэсэн үйл ажиллагааны талаарх санал сэтгэгдлийг Оюутны холбооноос зохион байгуулан суралцагчдаас авдаг.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг Дотоод хяналт, чанарын үнэлгээний албанаас авдаг. Тус судалгааны баримт материал нь цаасан хэлбэрээр Дотоод хяналт чанарын үнэлгээний албанд хадгалагддаг.
- Оюутны эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулдаг. Сүүлийн таван жилийн оюутны эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн жагсаалтыг судалгааны нэр, судлаач оюутан, эзэлсэн байраар жагсааж гаргасан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургуулийн бааз эмнэлгээс багш, ажилчид, суралцагчдад өвчнөөс урьдчилан сэргийлэх, амьдралын зөв хэвшил эзэмшүүлэхэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг.
- Бясалгал, мөргөл хийх, Зава цээжлэх
- Төгсөгч эмч нартай сар бүр уулзалт хийж, суралцах хугацаанд анхаарах зүйлс талаар ярилцлага хийдэг.
- Курсийн ажил бичдэг тул оюутнууд эрдэм шинжилгээний ажлын талаар тодорхой хэмжээний дадалтай болдог.
- Суралцагчид судалгааныхаа ажлын үр дүнд УАУ-ы зонхилох өвчний эмнэлзүйн удирдамж төсөл амжилттай гүйцэтгэж СА-д хүлээлгэн өгсөн.

Анхаарах асуудал:

- Оюутны зөвлөл өрөө байхгүй.

- Оюутныг зөвлөх, хөгжүүлэх үйл ажиллагааг сэтгэл ханамжийн судалгаа, зөвлөн туслах үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгаанд үндэслэн гаргах.
- Оюутанд чиглүүлэн зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг сургуулийн алба нэгж тус бүрээр гүйцэтгэх ажлын жагсаалтыг гаргасан ч, арга хэмжээ тус бүрийн төсөв, гүйцэтгэлийн тайлан мэдээ хангалтгүй, дутуу, эмх цэгц багатай байна.

Шаардлага:

- Оюутанд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэлийн тайланг нэгтгэж байх
- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайланг жил жилээр архивлаж, баримт бичгийг эмх цэгцтэй болгох
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, баримт материалыг жил жилээр архивлан баримт материалыг эмх цэгцтэй болгох
- Тухайн хичээлийн жилд оюутны дунд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдсэн байдлаар Оюутны албанаас гаргаж сургуулийн захирлаар батлуулан хэрэгжүүлж, үйл ажиллагаа тус бүрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг нэгтгэн архивлах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны сайн дурын клубүүд үйл ажиллагаа явуулдаг, үйл ажиллагааны тайлан мэдээг баримт бичгээр нотолгоожуулсан.
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшууллын дүн мэдээг нэгтгэсэн.
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээг гаргасан.
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүн мэдээтэй.
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоог гаргасан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Оюутны сайн дурын 4 клуб үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:
 1. “Тунгаамал”-нийгэм хүмүүжлийн сайн дурын үйл ажиллагаа тухайлбал Төвд хэлний тэмцээн, Тунгаамал цуврал лекцийг зохион байгуулдаг.
 2. “Эрдэм судлал”-ын клуб нь оюутны эрдэм шинжилгээ, төгсөлтийн курсийн ажил бичих дадал олгох зорилготой.
 3. “Асрахуй клуб” нь өндөр настан, асрамжийн газрын хүмүүст зөвлөгөө, тусламж мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулдаг.
 4. “Гадаад хэл сонирхогчдын клуб” нь 2019 он 10 сарын 1 өдрөөс хичээллэж эхэлсэн.

- Сайн дурын ажлын үнэлгээг сургуулийн болон хөтөлбөрийн шилдэг оюутан тодруулах үйл ажиллагаанд нэг шалгуур болгох, сургалтын тэтгэлгийн шалгуур болгох, төгссөний дараах нийгмийн идэвх оролцоог үнэлэх байдлаар үнэлгээ хийгддэг.
- Цагийн ажил эрхэлдэг оюутны тоо 164 буюу 55 % эзэлдэг. Үүнээс 3 курсийн оюутнууд дийлэнх хувь буюу 32% эзэлж байна. Нийт ажил цагийн ажил эрхэлдэг оюутны 23% буюу 45 оюутан өөрийн эзэмшиж байгаа мэргэжлийн чиглэлээр ажилладаг байна.
- Сургуулийн хэмжээнд шатар даам, сагсан бөмбөг болон гар бөмбөгийн тэмцээн тогтмол зохион байгуулдаг. Ижил мэргэжлийн сургуулиудын мэргэжлийн чиглэлээр зохион байгуулсан тэмцээнд амжилтай оролцож байсан. Тухайлбал: Шашны их сургуулиас зохион байгуулсан Төвөд хэлний тэмцээнд таван оюутан оролцож 3-р байр эзэлсэн.
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын хувьд нийт оюутнаас сүүлийн таван жилд 103 оюутан төрөөс үзүүлэх оюутны зээл тусламжид хамрагдсан байна. Төрийн бус байгууллагын тэтгэлэг хөтөлбөрт нийт 9 оюутан хамрагдсан. 2018-2019 оны хичээлийн жилд Төрийн сангийн оюутны хөгжлийн зээлд 113 оюутан хамрагдсан. Тус сургуулийн захирлын нэрэмжит тэтгэлэг нь дараалан гурван улиралд 3,8 болон үүнээс дээш үнэлгээтэй оюутанд олгодог бөгөөд 2015, 2016 онд тус хөтөлбөрөөр суралцагч 2 оюутан болзолыг биелүүлж тэтгэлэг авсан байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлэх эрхзүйн зохицуулалт байхгүй.

Зөвлөмж:

- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлэх эрхзүйн зохицуулалттай болох

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа хийсэн.
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журамтай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа сүүлийн гурван жилээр хийгдсэн байна. 2019-2020 оны хичээлийн жилийн шилжилт хөдөлгөөнийг авч үзвэл нийт 312 оюутнаас сургуулиас бүр мөсөн гарсан 23 оюутан байна. Энэ нь өмнөх жилээсээ 52%-иар өссөн байна.

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг оюутны албанаас судалгаа гаргаж, Сургалтын албанд танилцуулж, сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэдэг.
- Оточ Манрамба ИС-ийн хичээл сонгох, дүйцүүлэн хаах журмын дагуу дараах тохиолдолд багц цагийг дүйцүүлдэг байна. Үүнд: Жилийн чөлөөнөөс орж ирэх, хөтөлбөр хооронд шилжих, ижил мэргэжлийн дипломтой элсэгч анги дэвшин суралцах. Шилжилт хөдөлгөөний дүрэм журам нь оюутны гарын авлагад тусгагдсан.

Онцлог зүйл/Туршлага:

- Өмнө нь өөр мэргэжлээр суралцсан хүмүүс УАУ-ыг сурч судлахаар элсэн суралцаж байдаг.

Анхаарах асуудал:

- Сургуулиас бүр мөсөн гарсан оюутны тоо өссөн.

Зөвлөмж:

- Сургуулиас гарсан оюутны тоо өссөн шалтгааныг судалж үзэх, түүнээс сэргийлэх арга хэмжээ авах

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичиг, онолын болон диплом хамгаалсан бичиг баримтыг архивлан хавтасласан.
- Төгсөлтийн баримт бичгийг олгох тухай сургуулийн захирлын тушаал, БШУЯ-ны дипломын дугаар олголт тохирсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Оточ Манрамба ИС-ийн УАУ-ы их эмчийн хөтөлбөрийн 220 кредит цагийн хичээлийг 6 жилийн хугацаанд бүрэн судалсан суралцагч диплом хамгаалах, улсын шалгалт гэсэн 2 шалгалтыг өгч төгсдөг. Төгсөлтийн үйл ажиллагаа нь БСШУ-ы сайдын 2006 оны 12-р сарын 29 өдрийн 480 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын диплом олгох журам”, БСШУ-ы сайдын 2012 оны 01-р сарын 02 өдрийн 01 тоот тушаалаар батлагдсан загвар, БШУ-ы сайдын 2014 оны 03-р сарын 13 өдрийн А/78 тушаал, Оточ Манрамба ИС-ийн диплом олгох журмын дагуу төгсөгчдөд дээд боловсролын диплом олгодог.
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдлын тухайд бакалаврын сургалтын алба, оюутны албанаас төгсөх оюутнуудыг захирлын тушаалаар баталгаажуулж БШУЯ-наас дипломын дугаар олгогдсон оюутанд бакалаврын диплом гардуулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Дипломын ажил бичдэг нь давуу тал.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн бодлогын баримт бичигтэй.
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/ хийсэн.
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 3 жилээр/ хийсэн.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаатай.
- Багш нарт олгосон урамшууллын судалгааг хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Оточ Манрамба ИС-д багш сонгон шалгаруулж авахдаа Манба Дацан МУЭСТ-ийн хөдөлмөрийн дотоод журмын хоёрдугаар бүлгийн хөдөлмөр зохион байгуулалт заалт, Оточ Манрамба ИС-ийн 2016 онд батлагдсан багш сонгон шалгаруулж авах журмуудыг удирдлага болгодог байна.

- Багшийн зэрэглэл профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн зэрэглэлтэй. Үндсэн багшийн тоо 49, үүнээс профессор 29%, дэд профессор 2%, ахлах багш 17%, багш 46%, дадлагажигч багш 29 % эзэлж байна.
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааг сүүлийн гурван жилээр хийснийг дүгнэж үзвэл нэг багшид ногдох оюутны тоо 7.5-8.1 байна.
- Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний кредит цагт үндэслэн багшлах боловсон хүчнийг төлөвлөдөг. Үндсэн болон цагийн багшийн кредит цагийн ачааллыг сүүлийн гурван жилээр үзүүлснийг дүгнэж үзвэл үндсэн багш дунджаар 310-350 кредит цаг, цагийн багш 170-185 кредит цагийн хичээл тус тус биелүүлж сургалтын 65-70%-ийг үндсэн багш, үлдсэн хувийг цагийн багш биелүүлдэг.
- 2018-2019 оны хичээлийн жилд багшийн ажлын цагийн ногдолыг тогтоох журам шинэчлэгдэж онооны зарчимд шилжсэн. Багшийн албан тушаалын зэрэглэлд сургалтын ачааллыг тухайн хичээлийн жилд сургалтад зарцуулах оноог багц цагт шилжүүлэн тооцож үзвэл профессор багш 18,5 кр, дэд профессор 21 кр, ахлах багш 30кр, багш 30 кр, дадлагажигч багш 23 кр байна.

- Багш нарын цалин хөдөлмөрийн хөлсийг МУ-ын инфляцын түвшинтэй уялдуулан шинэчлэн баталж мөрддөг. Цалингийн өсөлтийг сүүлийн гурван жилээр хийснийг дүгнэж үзвэл 2019-2020 онд 19% нэмэгдэж 850 мянган төгрөгөөс нэг сая төгрөгт хүрсэн.
- Багш нарын шагнал урамшуулалд хамрагдсан байдлын судалгааг дүгнэж үзвэл жилдээ 5-8 багшийг төрийн ба төрийн бус байгууллагын шагнал урамшуулалд тодорхойлж, байгууллагын шагнал урамшуулалд 5 багш ажилчдыг хамруулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Ажилчдад орон байрны хүүгүй зээл олгодог.
- Багш сургуулийнхаа магистрантурт элсэн суралцахад сургалтын төлбөрийн 10-20 хувийг хөнгөлдөг.
- УАУ-ы салбарын багш нар сар бүр мэргэжлийн онолын мэдлэгийн шалгалт өгч, шалгалтад авсан үнэлгээнээс хамаарч нэмэгдэл цалинг тооцож олгодог.
- УАУ-ы мэргэжлийн онцлогоос шалтгаалан өөрийн төгсөгчдөөс багшаар сонгон авдаг.
- Багшийн багц цагийн ачааллыг оноогоор тооцдог. Үүнд тухайн хичээлийн жилд 1 багш нийт 1600 оноо цуглуулах ёстойгоос, 1000 оноо нь сургалтын буюу А цаг, 300 оноо нь эрдэм шинжилгээ буюу Б цагт, мэргэжлийн үйл ажиллагаа 300 оноо С цагт тооцогддог.

Анхаарах асуудал:

- Багшийн багц цагийн ачааллын хувьд сургалтын цаг илүү байдаг.
- Үндсэн багшийн тоо ӨҮТ-д хангалттай байдлаар 49 гэж бичигдсэн ч багш нарын өрөө нэг байдаг, 10 багш суудаг.
- Багш нарын төлөөлөлтэй уулзалт хийхэд нийт 8 багш оролцсоноос 2 багш 6 жил багшаар ажиллаж байгаа үлдсэн 6 багш 1-2 жил багшийн ажил хийсэн туршлагатай.
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа хийгээгүй байна.

Зөвлөмж:

- Багшийн нарын цагийн ачаалалд А цагийн ачаалал, заадаг хичээлийн тоог тодорхой хэмжээгээр бууруулан, эрдэм шинжилгээ, багшийн хөгжилд зориулах цагийг нэмэгдүүлэх
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа хийх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшлахуйн ур чадварыг хөгжүүлэх, дэмжих зорилготой багшийн хөгжлийн төв 2019 онд байгуулагдсан.
- Багшийн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт, бүтээлийн хуулбарыг нэгтгэсэн.
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаатай.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

- Тайвань Улсын Их дээд сургуулиудад 1 багш докторантур, 2 багш магистрантурт, БНХАУ-ын ӨМӨЗО-нд 1 багшийг магистрантурт сургууль хоорондын гэрээний дагуу суралцуулж зэрэг хамгаалсан.
- Оточ Манрамба ИС-ийн Багшийн хөгжлийн төв 2019 оны 5 сард байгуулагдаж “Багшийн эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа”-г авч судалгааны үр дүнгээр 2019 оны 05 сарын 30 өдрөөс 2020 оны 12 сарын 18 өдөр хүртэл нийт 11 удаагийн лекц сургалт зохион байгуулсан.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын эмнэлзүйн ур чадварыг сайжруулахын тулд эмнэлзүйн конференцийг жилдээ 5 удаа зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө байхгүй.
- Багш нарт Анагаах ухааны боловсрол судлалын мэдлэг дутмаг байна.

Шаардлага:

- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх 5 жил, 10 жилийн хөтөлбөр төлөвлөгөөтэй болох
- Багш бүр хөгжлийн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг жил бүр бичиж, Дотоод хяналт үнэлгээ, чанарын албандаа тайлагнаж үнэлүүлэх
- Дотоод хяналт үнэлгээний албанаас багшийн хөгжлийн хөтөлбөрийн тайланг жил бүр дүгнэж багшийн чанарын үнэлгээг тооцох
- Багш нарт Анагаах ухааны боловсрол судлалын мэдлэг, чадварыг олгох

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инновац, ашигтай загвар, патентын тоон судалгаа хийсэн.
- Бодлогын баримт бичиг, дүрэм журамтай.
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан.
- Нийтлэгдсэн бүтээл 261, судалгааны ажил 11.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Монгол улсын эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээг 2008-2015 он хүртэл хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд орсон УАУ-ы тэргүүлэх чиглэл дагуу 12 чиглэлийг тодорхойлсон баримт бичигтэй.
- Сүүлийн таван жилд тус сургуулийн 24 багш дээрх судалгааны таван чиглэлээр АУ-ы магистр зэрэг, хоёр багш АУ-ы докторын зэрэг хамгаалсан байна.
- Сүүлийн таван жилд гадаад дотоодын хамтарсан 6 төсөл хөтөлбөр хэрэгжсэн.
- 2014-2017 оны хичээлийн жилүүдэд Оточ Манрамба ИС-ийн багш нар нийт 261 оюуны бүтээл туурвисан. Үүнээс эрдмийн зэрэг хамгаалсан нэг сэдэвт бүтээл 6, эрдэм шинжилгээний илтгэл 111, дотоодод хэвлүүлсэн өгүүлэл 21, гадаадад хэвлүүлсэн бүтээл 16, эрдэм шинжилгээний өгүүлэл 35, ном бурах бичиг гарын авлага 63, оновчтой санал, шинэ бүтээл, улсын стандарт, патент авсан бүтээл 24.
- Багш бүр оюутны эрдэм шинжилгээ, дипломын ажлыг удирдан чиглүүлдэг.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар оюутны бакалаврын дипломын ажлыг удирдан хамгаалуулдаг.
- УАУ-ы чиглэлийн ном сурах бичиг гарын авлагыг сургуулийн багш нар туурвидаг.
- Оточ Манрамба дээд сургуулийн бакалавр, магистрын судалгааны ажлын эмхэтгэл-1, 2 тус тус 2007, 2012 онд хэвлэгдэн гарсан.
- Уламжлалт анагаах ухаан сонин эрхлэн гаргадаг. 2016 оноос Уламжлалт анагаах ухаан сэтгүүл эрхлэн гаргасан.

Анхаарах асуудал:

- ӨYT-ын Зураг 85-д долоон үзүүлэлт бүхий диаграмм байхад түүний тайлбар таван үзүүлэлт байх бөгөөд тайлбарын нэршил оновчтой бус нийтлэг эрдэм шинжилгээний бүтээл гэж тусгасан.
- Багш нарын бүтээлийн жагсаалтад доктор, профессор цолтой 5 багшийн бүтээлүүд дурдагдсан, бусад багш нарын нэр бүхий бүтээл ороогүй.
- Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтад сүүлийн таван жилээс өмнөх бүтээл 50% эзэлж байна. Зарим бүтээлд он, хугацааг тусгаагүй.
- Зарцуулсан төсөв, тайлан тодорхойгүй.
- Багш тус бүр тухайн хичээлийн жилийн эрдэм шинжилгээний тайланг тусгаа гаргадаггүй, жилийн үйл ажиллагааны тайландаа нэгдсэн байдлаар бичдэг.

Зөвлөмж:

- Багш бүр тухайн хичээлийн жилийн эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөн, гүйцэтгэлийн тайланг эрдэм шинжилгээний бүтээлийн хуулбарын хамт эрдэм шинжилгээний бүтээлийн хавтастаа хавсаргаж байх
- Багш судлаачдын эрдэм шинжилгээний ажлыг ижил төстэй сургуулийн багш нартай хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохиож, оролцож туршлага солилцон, чадавхжуулах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Оточ Манрамба ИС-ийн багшийн ачаалал тооцох, гүйцэтгэл үнэлэх журам 2014
- Оточ Манрамба ИС-ийн багшийн ажлын ноогдлыг тогтоох журам
- Багшийн хавтастай

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

- Оточ Манрамба ИС-ийн багшийн ачаалал тооцох, гүйцэтгэл үнэлэх журам (2014 он) дагуу багшийн ажлын төлөвлөгөөг хичээлийн жил бүр, үйл ажиллагааны 5 чиглэлээр боловсруулж, тухайн хичээлийн жилийн зорилтоо дэвшүүлж хэвшсэн.
- Тухайн жилийн ажлын гүйцэтгэлийн тайлан бичдэг.
- Багшийн хавтас бүрдэл 4 хэсэгтэй. Үүнд Ерөнхий танилцуулга хэсэг, заадаг хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, эрдэм шинжилгээний бүтээл, мэргэжлийн ахиц гэсэн бүрдэлтэй. Багш тус бүрийн хавтсыг үзэхэд эрдэм шинжилгээний бүтээл цөөн буюу зарим багшид байхгүй.
- Багш өөрийн үнэлгээний тайлан бичдэггүй.

Онцлог зүйл/Туршлага:

- Оточ Манрамба ИС нь УАУ-ы их эмчийн хөтөлбөрт багшилж буй УАУ-ы үндсэн багш нараас сар бүр мэргэжлийн онолын шалгалт авдаг.

Анхаарах асуудал:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг бичдэггүй.
- Хөндлөнгийн үнэлгээний дүн мэдээ нэгтгэгдээгүй.
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ нэгтгэгдээгүй.

Шаардлага:

- Цаашид өөрийн үнэлгээний тайланг бичиж Дотоод хяналт үнэлгээ, чанарын албандаа илгээж, үр дүнг тооцдог байх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан.

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын

механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Хөтөлбөрийн хороод ажилладаг
- Оточ Манрамба ИС-ийн Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам
- Суралцагч, багш, төгсөгч, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

- Оточ Манрамба ИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө (2014-20178 2017-2021), Оточ Манрамба ИС-ийн Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам (2016), Оточ Манрамба ИС-ийн хөтөлбөрийн хорооны журам (2016) зэрэг баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрддөг.
- Дотоод хяналт шинжилгээ, чанарын үнэлгээний албанаас УАУ-ы элсэлт болон төгсөлтийн үйл ажиллагаанд жилд нэг удаа, төгсөлтийн үйл ажиллагаанд жилд 2 удаа хяналт, шинжилгээ хийдэг. Хяналт шинжилгээ хийсэн тайланг архивласан.
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр оюутны, багш ажилчдын болон төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа хийдэг. Судалгааны асуумж хуудсыг архивлаж хавтасласан.

Анхаарах асуудал:

- Тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны хяналт үнэлгээтэй холбоотой архивын материалыг эхний хуудсанд гарчиглан, товьёг гаргаагүй.
- Суралцахуйн үр дүн, дүн шинжилгээ оновчтой биш.
- Дотоод хяналт шинжилгээ, чанарын үнэлгээний алба хариуцсан ажилтан байдаг. Тус алба нь тусгай нэгж өрөөгүй.

Шаардлага:

- Тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны хяналт үнэлгээтэй холбоотой архивын материалыг товьёг хийж, эмх цэгцтэй болгох.
- Суралцахуйн үр дүн, дүн шинжилгээг оновчтой болгох тухайлбал хичээлийн оношлол, явц, эцэст үнэлгээ өгөх; суралцагчийн үнэлгээ (багш өөрийгөө үнэлэх), дүн шинжилгээ, сайжруулалт гэсэн шалгуураар багш хичээлийн жилийн эхэнд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган сургалтын явцад заасан хичээл тус бүр дээр хийж гүйцэтгэн тайлагнах.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- Оточ Манрамба ИС-ийн нийт төгсөгчдийн ажил эрхлэлтийг салбар, төрийн байгууллага, хувийн хэвшил, гадаад, дотоодод ажиллаж буй байдлаар нэгтгэн дүгнэжээ.
- УАУ-ы их эмч мэргэжлээр төгсөгчдийн 96,08% нь үндсэн мэргэжлээрээ ажиллаж байна.
- Эрүүл мэндийн салбарын хувийн хэвшлийн эмнэлэг сувилалд 187 төгсөгч ажиллаж байна.
- Боловсролын салбарт багшаар 18, эрдэм шинжилгээний ажилтан 4, тэнхимийн эрхлэгч 3, сургалтын албанд 2, төгсөлтийн дараах албанд 2, захирал 6 төгсөгч ажиллаж байна.
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг авч үзвэл нийт 172 төгсөгчөөс 134 захирал, 14 тасгийн эрхлэгч, 2 сургалтын албаны дарга, 9 чанарын менежер, 7 төгсөлтийн дараах албанд, 6 эрхлэгчийн ажил хийж байна.
- Сургалтын хөтөлбөрийг сайжруулах, оролцогч талуудын эрэлт хэрэгцээг хангах үүднээс 20 хүний бүрэлдэхүүнтэй хөтөлбөрийн ерөнхий хороо болон дэд хороод ажилладаг. (Оточ Манрамба ИС-ийн захирлын 2016 оны А/25 тоот тушаалын хавсралт 1)
- Хөтөлбөрийн хороо нь салбар хороодоос ирүүлсэн хөтөлбөрийн чанарын өөрийн үнэлгээний тайланг Сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн алба, Оточ Манрамба ИС-ийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж, үр дүнг нэгтгэн дүгнэж захирлын зөвлөлд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулдаг.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа авдаг. Үүнд: ажил олгогч санал асуулгад оролцох, албан ёсны гэрээ хийх, хамтарч ажиллах байдлаар, оюутан санал асуулгад оролцох, хүсэлт гаргах, мэргэжил сурталчлах байдлаар, төгсөгч санал асуулгад оролцох, хүсэлт гаргах, хамтарч ажиллах байдлаар, хандивлагч хөрөнгө оруулалт хийх байдлаар, гадаадын хамтын ажиллагаатай сургууль нь хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарч ажиллах байдлаар, мэргэжлийн холбоод, зөвлөлүүд хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт хийх, сайжруулалтад саналаа өгөх байдлаар оролцдог байна.
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг санал асуулгын аргаар хийж, дүн шинжилгээ хийж, УАУ-ы тэнхимийн ажлын төлөвлөгөөнд тусгаж, тусгай журам гаргаж мөрдөж ажиллаж байгаа.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн судалгааны номтой. Үүнд: төгсөгчдийн ажил эрхлэлт, карьерын өсөлт, мэргэжил дээшлүүлэлт талаарх мэдээллийг нэгтгэсэн.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ хийгдээгүй.
- Хөтөлбөрт оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд хийсэн дүн шинжилгээг багшийн онолын мэдлэгийг тогтмол хянаж, үнэлэлт өгөх, оюутны ахиц дэвшлийг үнэлэх “Явцын үнэлгээ” зэрэг сургалтын үйл ажиллагааны үнэлгээ байдлаар явцуу ойлгож байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгааг хийх.
- Төгсөгчид, ажил олгогчдын ярилцлагаас дүгнэж үзвэл багшлах боловсон хүчний тогтвор суурьшил, ур чадварт анхаарах, өрнийн анагаах ухааны хичээлийн чанарыг сайжруулах тухайд санал оруулж байсан тул цаашид анхаарч ажиллах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдө

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэртэй.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/ хийсэн.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээтэй.
- Дотоод гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн судалгааг хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- БСШУ-ы сайдын 2015 оны 09 дүгээр сарын 18-ны А/364 тоот тушаалаар 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн Оточ Манрамба ИС болсон.
- 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн БСШУЯ-ны сургалтын ажил эрхлэх 960026 тоот тусгай зөвшөөрлийн дагуу Докторын сургалт явуулах эрх авсан.
- 2018 онд Оточ Манрамба ИС нь 3 дахь удаагаа амжилттай магадлагдсан.
- БШУЯ, МХЕГ-аас элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааны хяналт шалгалтад жил бүр хамрагдаж илэрсэн зөрчил дутагдлыг засаж сайжруулж, ололт амжилтаа ахиулдаг.
- УАУ-ы их эмчийн нийт төгсөгчид “Эмчлэх, сувилах эрхийн шалгалтыг”-ыг амжилттай өгдөг. Сүүлийн таван жилийн төгсөгчдийн мэргэжлийн зэрэг

ахиулсан байдлын судалгааг авч үзвэл зөвлөх зэрэгтэй, тэргүүлэх зэрэгтэй эмч 13, ахлах зэрэгтэй эмч 66 байна.

- УАУ-ы их эмчийн нийт төгсөгчдийн боловсролын зэрэг ахиулсан байдлын судалгааны дүн мэдээ: Нийт төгсөгчдийн 23,72% буюу 147 төгсөгч мэргэжлийн зэргээ ахиулжээ. Үүнээс 8 төгсөгч доктор (3 нь дотоодод, 5 төгсөгч гадаадад), 139 төгсөгч магистр (123 төгсөгч дотоодод, 16 төгсөгч гадаадад) зэргийг тус тус амжилттай хамгаалжээ.
- Оточ Манрамба ИС-ийн төгсөгчдөөс Эрүүл мэндийн дэд сайд, мэргэжилтэн, Эрүүл мэндийн хөгжлийн төв, МХЕГ, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, гадаад улс оронд мэргэжлээрээ ажиллаж байна. Нотолгоог зургаар оруулсан байна.
- Оточ Манрамба ИС-ийн төгсөгчдийн судалгаанаас харахад хувийн хэвшлийн эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлж байгааг дурьдвал “Сумади”, “Чимэд дүдзи”, “Монгол оточ уламжлалтын бариа заслын төв”, “Егнин”, “Тэнгис Мед”, “Гэгээн Манал”, “Болор шим”, “Сумандбадраа”, “Очир Мутар”, “Манчинпэлжид”, “Чин-Ачлал”, “Оюу дээвэр”, “Ачит гаа”, “Төмөрбаатар оточ” зэрэг эмнэлэгүүд байна.
- Оточ Манрамба ИС-ийн төгсөгчид гадаадын 11 улсад Англи, Польш, Турк, ОХУ, Буриад, Тува, Хятад, Солонгос, Япон, Швейцарь улсад ажиллаж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн амжилт бүтээлийг сургуулийн веб хуудас болон фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилдаг.
- УАУ сониндоо төгсөгчдөө урьж УАУ-ы талаар ярилцлага хийж нийтэлдэг.
- Төгсөгчдийн “Тэжээхүйн ухаан” ТББ, “УАУ-ы онол хэлэлцүүлэх бүлэг” фэйсбүүк групп ажиллаж мэргэжлээ олон нийтэд сурталчилдаг.
- Төгсөгчдийн дунд спортын арга хэмжээ зохион байгуулдаг.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

ДҮГНЭЛТ

№	Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	1.2 1.3	1.1		Бүрэн хангасан.
2	Сургалтын үйл ажиллагаа	2.1 2.2	2.3		Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.1 3.2 3.3			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион	4.1 4.2			Бүрэн хангасан

	байгуулалт	4.3 4.4 4.5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5.1 5.3 5.4 5.5	5.2		Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	6.1 6.3	6.2 6.4		Хэсэгчлэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	7.2 7.3	7.1		Бүрэн хангасан
		20	6		
	Дүгнэлт	Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Оточманрамба их сургуулийн “Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Ч.Чимэдрагчаа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг/Ч.Батнайрамдал/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Х.Туул/

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Сургуулийн нэр	Оточманрамба их сургууль
Хөтөлбөрийн нэр	“Уламжлалт анагаах ухаан”
Хөтөлбөрийн индекс	D091701
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал нь ДЭМБ болон Ази номхон далайн бүсийн орнуудын уламжлалт анагаах ухааны стратеги, бодлоготой уялдуулах.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	1. Сонгон суралцах хичээлүүдийн эзлэх хувь харьцааг нэмэгдүүлэх, хичээлүүдийг жигд хуваарилах.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	1. Цахим номын тоог олшруулж, цахим хичээлийн санг улам боловсронгуй болгон E-контент сургалтыг явуулах.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	1. Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй тусгах. 2. Нэг суралцагчдад ноогдох өртөг зардлын тооцоог тодорхой болгох. 3. Цаг үеийн мэдээллийг тогтмол байршуулж, цахим мэдээллийн жагсаалтыг идэвхтэй байлган олон нийтэд ил тод, үнэн зөв мэдээлэх.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	1. Оюутны тоог нэмэгдүүлэх, маркетингийн сурталчилгааг идэвхжүүлэх. 2. Оюутанд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэлийн тайланг нэгтгэж байх. 3. Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайланг жил жилээр архивлаж, баримт бичгийг эмх цэгцтэй болгох. 4. Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлэх эрхзүйн зохицуулалттай болох.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	1. Багшийн нарын цагийн ачаалалд А цагийн ачаалал, заадаг хичээлийн тоог тодорхой хэмжээгээр бууруулан, эрдэм шинжилгээ, багшийн хөгжилд зориулах цагийг нэмэгдүүлэх. 2. Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа хийх. 3. Багш өөрийн үнэлгээний тайланг бичиж Дотоод хяналт үнэлгээний албандаа илгээж, үр дүнг тооцдог байх. 4. Суралцахуйн үр дүн, дүн шинжилгээг оновчтой болгох тухайлбал хичээлийн оношлол, явц, эцэст үнэлгээ өгөх; суралцагчийн үнэлгээ (багш өөрийгөө үнэлэх), дүн шинжилгээ,

	сайжруулалт гэсэн шалгуураар багш хичээлийн жилийн эхэнд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган сургалтын явцад заасан хичээл тус бүр дээр хийж гүйцэтгэн тайлагнах.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ol style="list-style-type: none"> 1. Дотоод хяналт шинжилгээ, чанарын үнэлгээний албанаас багшийн хөгжлийн хөтөлбөрийн тайланг жил бүр дүгнэж багшийн чанарын үнэлгээг тооцох. 2. Тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны хяналт үнэлгээтэй холбоотой архивын материалыг товьёг хийж, эмх цэгцтэй болгох. 3. Дотоод хяналт шинжилгээ, чанарын үнэлгээний алба, нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулж чанаржуулах.
ШААРДЛАГА	
	<ul style="list-style-type: none"> • Оюутныг зөвлөх, хөгжүүлэх үйл ажиллагааг сэтгэл ханамжийн судалгаа, зөвлөн туслах үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгаанд үндэслэн гаргах. • Багш бүр өөрийгөө хөгжүүлэх 5 жилийн хөтөлбөр төлөвлөгөөтэй байж, өөрийн үнэлгээний тайланг жил бүр бичдэг байх. • Багш нарт Анагаах ухааны боловсрол судлалын мэдлэг, чадварыг олгох. • Багш судлаачдын эрдэм шинжилгээний ажлыг ижил төстэй сургуулийн багш нартай хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохиож, оролцож туршлага солилцон, чадавхжуулах. • Дотоод хяналт шинжилгээ, чанарын үнэлгээний алба болон оюутны зөвлөлийг өрөөтэй болгоход анхаарч ажиллах

Уулзалтад оролцсон нэрсийн жагсаалт
Оюутны төлөөлөл

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Болортуяа	1Б	Идэвхтэй	88082401
2	Молор-Эрдэнэ	1А	Ангийн дарга	80090033
3	Чулуунтулга	2А	Ангийн дарга	99936247
4	Чинзориг	3А	Манлайлагч	88477768
5	Отгонзаяа	3В	Ангийн дарга	89200226
6	Отгонтуяа	3Б	Идэвхтэй	91003819
7	Мөнх-Эрдэнэ	4А	Ангийн дарга	88837642
8	Ариунгэрэл	4Б	Ангийн дарга	88095925
9	Энхцэцэг	5А	Идэвхтэй	96791199
10	Ариунзаяа	5А		99120982
11	Наранцэцэг	6А	Ангийн дарга	99205627

Багш нарын төлөөлөл

Уулзалт хийх хугацаа 2021.05.14 14.00-15.30

№	Овог нэр	Албан тушаал	заах хичээл	Утас
1	Д.Отгонбаатар	УАУ-ы тэнхмийн эрхлэгч	Хүний биеийн бүтэц зүй, Эрүүл биеийн үйл зүй, эмгэг үйл зүй, бариа засал, УАУ-ы засал, УАУ-ы оношилгоо	91001055
2	Б.Ундрахтамир	УАУ-ы тэнхимийн багш	Дотор өвчин засал-1,2, Халуун өвчин, Гурван гэм, хурмал өвчин, Эм жор судлал технологи 1,2	99604373
3	Б.Аюушжав	УАУ-ы тэнхимийн багш	Хоол хүнс судлал, Эрүүл аж төрөхүй, Эм судлал эмийн түүхий эд-1, Эм жор судлал, технологи-1,2	80037200
4	Г.Ариунжаргал	УАУ-ы тэнхимийн багш	Таван эрхтэний өвчин, Адын өвчин, Эмэгтэйчүүдийн өвчин, Хүүхдийн өвчин, ГЭМтэлийн өвчин	99920520
5	Б.Батчимэг	УАУ-ы тэнхимийн багш	Төвөд хэл, Анагаахын ёс зүй-1, УАУ-ы онол зүй-1,2	99605567
6	Б.Одончимэг	УАУ-ы тэнхимийн багш	Төвөд хэл, Анагаахын ёс зүй-1, УАУ-ы оношилгоо, УАУ-ы засал	99230653
7	М.Золбоо	УАУ-ы тэнхимийн багш	Онош зүй, Эм судлал эмийн түүхий эд-1, Эрүүл аж төрөхүй, Ерөнхий англи хэл, Мэргэжлийн	91233322

			англи хэл	
8	Б.Буянжаргал	УАУ-ы тэнхимийн багш	Төвөд хэл, Анагаахын ёс зүй-1, УАУ-ы оношилгоо, УАУ-ы засал	86390508

Ажил олгогчдын төлөөлөл:

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас
1	Б.Баттөмөр	Егнин УАУ-ы эмнэлэг	70167611
2	Ц.Есөн-Эрдэнэ	Саманда бадра эмнэлэг, захирал	99098921
3	Г.Гантөмөр	Агь Манба УАУ-ы эмнэлэг	88037636
4	Ц.Хулан	Манба Дацан эмийн үйлдвэр	99336000
5	Р.Молор	Сумади эмнэлэг, эрхлэгч эмч	91319133
6	Б.Чойном	Авро мед эмнэлэг, захирал	91997131
7	Ц.Тэмүүлэн	Анагаагч тун	99075730
8	Б.Мөнгөнцэцэг	Манба Дацан эмнэлэг, эрхлэгч эмч	99330833

Төгсөгчдийн төлөөлөл

Уулзалт хийх хугацаа 2021.05.14 10.15-11.15

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас
1	Р.Цолмон	2004	Сумади эмнэлэг, захирал	99149133
2	Б.Болорчимэг	2010	Манба Дацан эмнэлэг	91011018
3	Л.Энх-Амгалан	2011	Манба Дацан эмнэлэг, их эмч	91991141
4	Н.Бүрэнтогтох	2013	Хөх Манал эмнэлэг захирал	89068699
5	Б.Батхуяг	2014	Хангайн манба дацан	99336280
6	Ч.Дэлгэрмаа	2015	Манба дацан эмнэлэг, их эмч	95101252
7	Д.Даваадорж	2016	Оюу толгой уурхайн эрхлэгч эмч	99197159
8	Ж.Гончигдорж	2018	Манба Дацан эмнэлэг, их эмч	80798999
9	Б.Гомбо	2020	Агь Манба эмнэлэг, их эмч	86628866

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



ОТОЧ МАНРАМБА ИХ СУРГУУЛЬ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 2 дугаар хороо,
Доржийн гудамж, Хоршооллын хотхон 80/3 байр

Улаанбаатар-49, Шуудангийн хайрцаг-235

И-мэйл: info@otoch.edu.mn

Вэб сайт: www.otoch.edu.mn

Утас: 7015 7489 Факс: 7015 8489

2021.06.22 № 01/35

танай _____-ны № _____-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД**

Шинжээчдийн дүгнэлтийн тухай

Манай сургуулийн “УАУ-ы хүний их эмчийн бакалаврын хөтөлбөр”-т
магадлан итгэмжлэл хийсэн БМИҮЗ-ийн шинжээчдийн багаас гаргасан
дүгнэлтийг зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ



Д.НАЦАГДОРЖ